Засгийн газрын хэрэг эрхлэх га
даргын 2023 оны 98 дугаар туша
6 дугаар хавс

**АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН БАЙЦААГЧ ТУЛГА ОВОГТОЙ ЭРДЭНЭПИЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Нэг.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн, дууссан хугацаа |
| | 1 | 2 | 3 | | 1 | 2 |
| *“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжи зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийв хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, ү дүгнэлт өгөх, санал боловсруулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | |
| 1 | Арга хэмжээ №1.1.1 Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг хэрэгжүүлж ажиллах. | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан хуулийн өөрчлөлтүүдийг зохион байгуулж ажилласан байх. | Нийгмийн даатгалын тухай хууль | Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт биелэсэн байна. | 1.2024.01.01-ээс эхлэн хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын багц хуулийн дагуу 803 өндөр насны, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр 147, тэжээгчээ алдсаны 41, тэтгэврийн тусгай зохицуулалт 54 малчины нөхцөлөөр 689, Цэрэг цагдаа 5, хувь тэнцсэн 42, хүүхдийн нөхцөлөөр 673 нийт 2454 тэтгэврийг хянан баталгаажуулсан байна.<br>2.Нийгмийн даатгалын байгц хуулийн дагуу 2024 оны 3 дугаар сард аймгийн Үсчдийн холбооны өдөрлөгт сургалт зохион байгуулсан байна.<br>3. Хяналтын байцаагч С.Насанбуян, Нийгмийн хамгааллын хяналтын байцаагч Б.Болор-Эрдэнэ нарт хяналт шалгалт хийх арга зүйн зөвлөгөө өгөн сурган ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.12.15 |
| 2 | Арга хэмжээ №1.1.2 Нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллах | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан тэтгэмж авагч нарын шинээр тогтоосон тэтгэмжийг хянан | 2023 онд нийт 1138 иргэний тэтгэмжийг шинээр тогтоож олгосон. | Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж хөдөлмөрийн чавдараа түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны, | 2024.01.01-2024.09.01-ний өдрийг хүртэлх хугацаанд өндөр насны 803, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр 147, тэжээгчээ алдсаны 41, тэтгэврийн тусгай зохицуулалт 54 нийт 1045 Жирэмсэн болон амаржсан тэтгэмж 1008, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 426, нас барсан даатгуулагчийн гэр бүлд олгох тэтгэмж 286, ажилгүйдлийн тэтгэмж 322 хянан баталгаажуулсан байна. | 2024.01.02<br>2024.12.15 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | баталгаажуулсан байх | | нас барагчийн ар гэрт олгох, ажилгүйдлийн тэтгэмжүүдийг хуулийн хугацаанд хянан баталгаажуулна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/51 тоот тушаалын дагуу тус газрын бүтэц орон тоо, зохион байгуулалтын нэгж өөрчлөгдөн миний бие нь Хяналт, шалгалтын байцаагчийн албан тушаалд томилогдож гадагшаа чиглэсэн хяналт шалгалтыг хийж тэтгэвэр тэтгэмжийг хянах чиг үүрэгт өөр байцаагч томилдогдон ажиллаж байна. | |
| 3 | Арга хэмжээ №1.1.3 Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтоож, олгох үйлчилгээний заавар”-ын дагуу тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэг, хавсаргасан холбогдох үндсэн баримтын тооллогыг бүтэн жилд хийж, тэтгэвэр олгосон файл, жагсаалттай тулган шалгаж баталгаажуулах, | Идэвхтэй, зогсоогдсон, нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж үр дүнг тооцож ажиллах. | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 15640 тэтгэврийн хувийн хэргийг тоолсон. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан /ЗН-НД-7/ маягтаар актыг 2 хувь үйлдэж, жилийн эцэст байвал зохих тэтгэвэр авагчийн тоог хувийн хэргийн тоотой тулган баталгаажуулсан байна. | 2024 оны тэтгэврийн хувийн хэргийг тоолох ажлын хүрээнд Эрдэнэбулган, Өлзийт, Өгийнуур, Батцэнгэл, Ихтамир, Жаргалант, Хашаат, Төвшрүүлэх, Хайрхан, зэрэг сумдын 9018 хувийн хэргийг тоолоход бүгд бүрэн байсан болно. 2024 оны жилийн эцсийн тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг дараа онд хийхээр төлөвлөн ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.12.15 |
| 4 | Арга хэмжээ №1.1.4 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг нарийвчлан гаргаж, | Газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуй нэгж, байгууллагуудыг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах арга | 2023 онд 11 ажил олгогчийг шинээр хамруулсан. | Шимтгэл төлөлтөнд шалгалт хийж илэрсэн зөрчлийн 70-с доошгүй хувийг | Газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр баталсан “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн хэрэгжилтийг аж ахуйн нэгж байгууллагад шалгах удирдамжийн дагуу тус аймагт үйл ажиллагаа явуулж буй 1-15, Ирээдүй цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагааны санхүүгийн баримтанд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Одоогоор | 2024.01.02<br>2024.12.15 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэдгээрийн шимтгэл төлөлтөд шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгах. | хэмжээ авч ажилласан байх | | арилгуулсан байна | шалгалтын дүн мэдээ нэгтгэгдээгүй, шалгалтын явц 80 хувьтай байна. | | |
| 5 | Арга хэмжээ №1.1.5 Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын хэмжээнд шалгалт хийж үр дүнг тооцох, илэрсэн төлбөр зөрчлийн барагдуулалтад хяналт тавих | Шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажилд үр дүнг тооцож ажилласан байна. | 2023 онд Цэцэрлэг, Өндөр-улаан, Тариат суманд нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. | Шимтгэл төлөлтөнд шалгалт хийж илэрсэн зөрчлийн 70-с доошгүй хувийг барагдуулсан байна | Шимтгэлийн урсгал өр авлагыг барагдуулахаар 8 ажил олгогчдод улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэх, 8 ажил олгогчдын арилжааны банкны харилцах дансны зарлагын гүйлгээг зогсоох, ажлын шимтгэлийн 2 байцаагчтай хамтран хийж гүйцэтгээд байна. Шүүхийн шийдвэр гарсан 1 аж ахуй нэгжийг шийдвэр гүйцэтгэх газарруу өгөөд байна. Хамралт орлого Шимтгэлийн өр хариуцсан 2 байцаагчтай сар улирлын эцэст хуримтлагдсан өртэй аж ахуй нэгж байгууллагуудын өрийн судалгааг гарган утсаар ярьж оруулах, албан шаардлага, данс хаах тухай мэдэгдэх арга хэмжээ авч ажиллаж байна. Шимтгэлийн авлагыг 100,0 сая төгрөг дотор гаргахаар зорин ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.12.15 | |
| 6 | Арга хэмжээ №1.1.6 Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, хяналт тавих, тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцох, | 2023 онд 6 ажил олгогчдод Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцон ажилласан. | 1.Зөрчил шалгасан байгууллага, иргэний тоогоор<br>2.Зөрчилтэй холбоотой улсын байцаагчийн актаар тавигдсан актыг 70-с доошгүй хувиар барагдуулсан байна.<br>3.Мэдээ тайланг цаг тухай бүрд нь хүргүүлсэн байна. | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>-Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нь нийгмийн даатгалын шимтгэлийг эрх бүхий байгууллагын тогтоосон хугацаанд төлөөгүй 3 аж ахуйн нэгж байгууллагад 25.1 сая төгрөгийн цалингийн санд 4,5 сая төгрөгийн шимтгэл, алдангийг ногдуулж, 3 нягтлан бодогчид хариуцлага тооцож шийтгэлийн хуудсаар 1,0 сая төгрөгийн торгууль оногдуулан зөрчлийг Хялбаршуулсан журмаар шийдвэрлэн ажиллаа. Мөн ажил олгогч нь тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, тайлагнаагүй зөрчилд “Шийтгэлийн хуудас”-аар 5 байгууллагын нягтлан бодогчид 1.250 сая төгрөгийн шийтгэл оногдуулсан бөгөөд нийт 4,5 сая төгрөгийн шимтгэл, алданги, 2,2 сая төгрөгийг тогуулийг нийгмийн даатгалын санд бүрэн төвлөрүүлэн ажиллаа.<br>-Хяналт шалгалт хийсэн 3 сумын төсөвт байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт Прокурорын байгууллагаас зохион байгуулсан зөрчлийн тухай хуулийн сургалтыг хийж, төрийн | 2024.01.02<br>2024.12.15 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах зөвлөмж гарган ажиллаа.<br>-Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлсэн байдлын судалгаа, мэдээ тайланг цаг тухай бүрд нь холбогдох байгууллагад нь хүргүүлэн ажиллаж байна. | |
| 7 | Арга хэмжээ №1.1.7 Хяналт шалгалтын тайлангийн үр дүнг тооцох, илэрсэн төлбөр зөрчлийн барагдуулалтад хяналт тавих | Тайлангийн тоон үзүүлэлтүүдийг сангийн гүйцэтгэлийн тайлантай тулган баталгаажуулсан байна. | Тайлан, мэдээг тогтоосон хугацаанд холбогдох газарт хэлтсийн даргын албан бичгээр хүргүүлэн ажилласан. | Дотоод хяналт шалгалтын 2024 оны хагас жилийн тайлан мэдээг нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулан тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын даргын 2024.05.29 өдрийн 01/1107 тоот, 2024.10.04 өдрийн 08/2075 тоот баталсан удирдамжийн дагуу хяналт шалшалт хийхэд Шүүхийн шийдвэрийн дагуу сар бүрийн олгох тэтгэвэрээс суутгал хийж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын холбогдох дансруу шилжүүлдэг 4 тэтгэвэр авагчийн 02 дугаар сарын тэтгэврээс шинэ Sicos программ нэвтэрч байгаатай холбоотой суутгал хийгээгүй олгосон, шүүхийн шийдвэрийн дагуу суутгал хийж буй тэтгэвэр авагч нарын олголтод зөрчил илрээгүй болно. Улсын байцаагчийн акт тогтоолгосон 71 тэтгэвэр авагчаас Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын дагуу, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасны дагуу сар бүр олгох тэтгэврээс 50 хувиар суутгал хийж ажиллаж байна. Мөн 2024 оны 02 дугаар сарын тэтгэврийг олгохдоо шинэ Sicos программ нэвтэрч байгаатай холбоотой суутгал хийгээгүй олгосон бөгөөд 2024 оны 03 дугаар сарын тэтгэврийг олгохдоо 100 хувь суутгал хийн олголтоос хасч холбогдох арга хэмжээ авч ажилласан. 2024 оны 01 сар, 03 сар, 04-06 саруудад дээрх 71 тэтгэвэр авагчтай холбоотой 129.830.019 мянган төгрөгний тэтгэврийн суутгал хийж улсын байцаагчийн актны биелэлтийг ханган ажиллаж байна.<br>15 тэтгэвэр авагчийн мэдээллийг Sicos программ дээр хөрвөж ороогүй үлдсэн насан туршийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр, шинээр тогтоож болохгүй гэх мэт ороогүй байгаагаас үүдэн эрүүл мэндийн даатгал нь төлөгдөөгүй төлөвтэй харагдаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүй иргэд гомдол мэдүүлээд байна.Тиймээс дээрх 15 тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоох болон сунгах | 2024.01.02<br>2024.12.15 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | асуудлыг шийдвэрлэж өгнө үү. Тэтгэвэр дээр 16932 тэтгэвэр авагчийн олголтыг шалгахад 12 тэтгэвэр авагчтай холбоотой 9,3 сая төгрөгийн зөрчил илэрсэн бүрэн барагдуулж, тэтгэмж дээр 1858 тэтгэмж авчаас 7 ажилгүйдлийн тэтгэмж авагчтай холбоотой 5,1 сая төгрөгийн зөрчил илэрч 1.03 сая барагдуулж ажиллаа. | |
| *"Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтла бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбө хэмжээ:*** | | | | | | |
| 1 | Арга хэмжээ №2.1.1 Дотоод хяналт шалгалтын тайлан мэдээ гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх, тайлагнах | Холбогдох дүрэм журам зааврын дагуу ажилласан байна. | Тайлан, мэдээг тогтоосон хугацаанд холбогдох газарт хэлтсийн даргын албан бичгээр хүргүүлэн ажилласан. | Дотоод хяналт шалгалтын 2024 оны хагас жилийн тайлан мэдээг нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулан тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн байна | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд "Дотоод аудит" хийх удирдамжийн дагуу тус газрын 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг дуусталх хугацааны Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулалт, өмнөх онд дээд газар болон холбогдох байгууллагуудаас өгсөн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтэд аудит хийсэн. Тус газар нь үйл ажиллагаа болон сантай холбоотой 327 мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулахаас 327 мэлдээллийг хугацаанд нь байршуулж, мэдээллэсэн бөгөөд шилэн дансны ил тод байдлыг 100%-н гүйцэтгэлтэй байна. | 2024.01.02<br>2024.12.15 |
| 2 | Арга хэмжээ №2.1.2 Нийгмийн даатгалын салбарын "Цахим хяналтын систем"-д тулгуурлан дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж, үр дүнг тооцох | Үр дүнг тооцож ажилласан байна | Цахим хяналтын програмаас тодорхой өгөгдлийн дагуу шүүлт хийж, зөрчилтэй байх магадлалтай мэдээллийг холбогдох | Нийгмийн даатгалын салбарын "Цахим хяналтын веб програм"-(http://10.9.0.5/monitoring)-аас тодорхой өгөгдлийн дагуу шүүлт хийж, зөрчилтэй байх магадлалтай мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн | НДЕГ-н Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 5-р сарын 01/1107, 10-р сарын 08/2075 дотоод хяналтыг сайжруулах ажлын хүрээнд цахим хяналт хийх албан бичгийн дагуу 2024 оноос салбарын хэмжээнд шинэ систем https://sicos.ndaatgal.mn/ хэрэгжилтэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллалаа. Шалгалтаар нийт 16932 тэтгэвэр авагчдын олголтыг шалгахад 12 тэтгэвэр авагчтай холбоотой 9.3 сая төгрөгийн зөрчил илэрч, улсын байцаагчийн акт тогтоосон бөгөөд актын биелэлтийг 100 хувь барагдуулан ажиллалаа. | 2024.01.02<br>2024.12.15 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгаж 96 хувь шийдвэрлэсэн | хийж, зөрчилтэй байх магадлалтай мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгаж 50 хувь шийдвэрлэсэн байна. | | |
| 3 | Арга хэмжээ №2.1.3 Шимтгэлийн өр авлагыг бууруулах ажлын хэрэгжилтэд хяналт тавих, удирдлагаар хангах | Шалгасан аж ахуй нэгжийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шалгаж, шийдвэрлэсэн байна. | 2023 онд 120 ба түүнээс дээш өртэй ажил олгогчийн 75 хувийн авлагыг барагдуулан ажилласан. | Шимтгэлийн болон сумын байцаагчтай хамтран 120 ба түүнээс дээш хоногийн насжилттай авлагын 60 хувийг барагдуулсан байна. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам"-н дагуу 2023 оны Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлага үүсгэсэн ажил олгогч нартай утсаар болон биечлэн уулзаж шинэ батлагдсан журмыг танилцуулан 5 байгууллагын 2,7 сая төгрөгийн өрөө барагдуулсан. Хуримтлагдсан шимтгэлийн авлага үүсгэсэн ААН, Байгууллагын судалгааг прокурорын байгууллагад хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>Нийт авлагын 45 хувийг төсөвт байгууллага үүсгэж буй учир нягтлан бодогч, н сарын эцэст тулган гүйлгээ хийхгүй байх Төрийн сан болон дарга нартай хамтран ажиллаж улирал бүр албан тоот хүргүүлж байна. | 2024.01.02<br>2024.12.15 |
| 4 | Арга хэмжээ №2.1.4 Иргэд даатгуулагч, ажил олгогчоос ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэж, үр дүнг тооцох | Хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна. | 2023 онд иргэд болон ажил олгогчоос ирсэн 5 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байна. | Иргэн, даатгуулагчаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэж, үр дүнг тооцон ажиллах | Монгол улсын Засгийн газрын 2023 оны 09 дугаар сарын 26-ны өдрийн 362 тоот тогтоолоор баталсан "Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм"-ийн дагуу НДГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/08 тоот тушаалаар Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн гишүүдийг томилон энэ онд 8 удаагийн хурлаар 137 иргэдийн өргөдөл гомдлийг хүлээн авч шийдвэрлэн 1 иргэний өргөдлийг хэлэлцэхээс татгалзан хариуг хүргүүлэн ажилласан. 8 удаагийн хурлаар 130 цаг хуралдан 3551556 төгрөгийн цалин хөлсийг олгон ажилласан байна. Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд 1 удаа өөрчлөлт оруулсан. | 2024.01.02<br>2024.12.15 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | Арга хэмжээ №2.1.5 Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 11 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Хяналт шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | 2023 онд 25 объектод хяналт шалтгалт хийж, 151 зөрчил илэрүүлж, албан шаардлага хүргүүлснээс 61.6 хувийн зөрчил аргилгасан байна. | Шалгалтад хамрагдсан объектод хууль сахин мөрдөлтийн түвшинг +10%, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт 70%, илэрсэн зөрчлийг 70% арилгуулах, объектын эрсдэлийн түвшинг бууруулна. | Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу Архангай аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй, нэгж байгууллагуудад төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн бөгөөд Архангай Авто зам ХХК, Гурвантамир ХХК, Эвт уул ХХК, Гост Трейд ХХК, Эсгэл ХХК, Саруул харгуй ХХК, Тамир таун ХХК, Ашид бэхи ХХК, Тамирын цахиур ХХК, Бага хангай ХХК, Газрын гагнаас ХХК, зэрэг 11 ААНБ-г Төрийн хяналт шалгалтын тухай, Нийгмийн даатгалын багц хууль, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Хяналт шалгалт хийх нийтлэг журам буюу 479 дүгээр тогтоолын" дагуу шалгаж, "Хяналт шалгалтанд хяналтын хуудас хэрэглэх журам, хяналтын хуудас шинэчлэн батлах тухай" Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/42 дугаар тушаалаар баталсан Ажилтны Нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас 07.3.1-ээр эрсдэлийн болон хууль сахин мөрдөлтийн түвшинг тогтоож улсбн байцаагчийн акт тавьж, Төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамрагдсан Архангай Авто зам ХХК-д 5.830.0 мян төгрөгийн орлогод ногдох 843.407 мян төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож 100% барагдуулаад байна. Мөн дээрх байгууллагуудад нийтлэг илсэрсэн зөрчил нь ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах талаар авсан арга хэмжээ, үр дүн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ бусад нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар гаргасан тушаал заавартай танилцаж хөдөлмөрийн дотоод журамд ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил асуудал тусгаж хэрэгжүүлээгүй, ахмадын сан байгуулаагүй, | 2024.01.02<br>2024.12.15 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийгмийн даатгалын шимтгэлд ноогдох орлогыг үнэн зөв тодорхойлоогүй, ААНБ-с ажилтанд хоол, унаа, түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт үзүүлэх талаар дотоод журам хөдөлмөрийн гэрээнд огт тусгаагүй, ажилчидын ээлжийн амралтыг бодитоор бодож олгоогүй, ажил мэргэжлийн ангилал хэсгийг үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтод заасны дагуу үнэн зөв хийгээгүй, Ажилд орсон, чөлөөлсөн, мөн өөрчлөлт орсон тушаалыг тухай бүр шимтгэлийн цахим системд оруулаагүй нь Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх А/199 журам болон Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмйин даатгалын ерөнхий хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу Ажил олгогч нь нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх зорилгоор шимтгэл ногдох орлогыг нуусан, эсхүл хэмжээг нь санаатайгаар бууруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн заалтыг зөрчсөн байх тул зөрүүн дээр нь улсын байцаагчийн акт тавьна гэтэл танай байцаагч нар мэдэж байгаа хэрнээ ингэж төлөхгүй тухайн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ эсвэл бодит цалин орлогоос төлөх ёстой тэгэхгүй бол зөрүүн дээр нь акт тавьна гэж хэлж байгаагүй тийм болохоор болоод байна гэж бодоод л ингээд төлдөг бид нар хүлээн зөвшөөрөхгүй харин танай байцаагч нар албан үүргээ хангалтгүй биелүүлсэн байна. Тайлан баталгаажуулаад авсан юм чинь хариуцаж байсан байцаагч нар дээр нь тэр актаа тавь гэдэг тайлбарыг өгсөн тул цаашдаа бодит цалин хөлснөөс болон салбарын хөдөлмөрийн хөлснөөс дээгүүр тооцож НДШ-төлж ажиллах тал дээр анхаарч ажиллах талаар зөвлөгөө өгсөн. Дээрх ААНБ-уудын хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 82,5%, эрсдэл үүсэх магадлал дунд гэж үнэлэгдлээ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ №2.1.6 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг баримтлан, хяналт тавьж хийсэн ажлын тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Дотоод аудит, мониторингийн газарт хүргүүлнэ. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулсан байна. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулсан байна. | Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг ажилдаа мөрдлөг болгон мэдээллийн сайтад Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, сангийн болон үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг батлагдсан маягтын дагуу сар, улирал бүр мэдээг НДС, НДГазар тус бүрээр нь гаргаж хуулийн хугацаанд нь тогтмол мэдээллэж ажилласан. Үүнд: НДС дээр 28 чиглэлээр 158 мэдээлэл, НДГ нь 29 чиглэлээр 169 нэр төрлийн мэдээллийг хуулийн хугацаанд нь ил тод мэдээлэлсэн байна. Хугацаа хоцроосон мэдээлэл жилийн эцсийн байдлаар гараагүй болно. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 08 өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан гуравдугаар хавсралтаар цахим хуудсанд байршуулах нээлттэй байршуулах 48 мэдээллийн цаг хугацаанд нь байршуулсан байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024.06.10 өдрийн 03/1203 албан тоотын дагуу Shilen.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийг хянан тайланг хуулийн хугацаанд илгээн ажиллаа. | 2024.01.02<br>2024.12.15 |
| *"Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | |
| 1 | Арга хэмжээ №3.1.1 Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх | Албан хаагчийг эзгүй байгаа үед орлон гүйцэтгэн ажилласан байна. | . | Тушаалын хэрэгжилт хангагдсан байна. | 2024 онд миний албан тушаалын чиг үүрэгт хамаарал бүхий албан хаагчийн ажлын байр эзгүй тохиолдол гараагүй байна. | 2024.01.02<br>2024.12.15 |
| 2 | Арга хэмжээ №3.1.2 Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллах үүрэг хүлээх | Аливаа мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажилласан байна. | 2023 онд ажил олгогч даатгуулагчаас санал гомдолгүй ажилласан. | 1.Ажил олгогч, даатгуулагчдын эрх ашиг хамгаалагдсан байна. | Байгууллагын нууцын тухай болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу байгууллагын нууцын ажилтантай гэрээ байгуулан ажил олгогч, даатгуулагчийн мэдээлэл задруулалгүй ажилласан бөгөөд Нууцын тухай хуулийн дагуу байгууллагын нууцын ажилтанаар томилогдхоор эрх | 2024.01.02<br>2024.12.15 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2.Иргэд, ажил олгогчоос санал гомдол гараагүй байна. | бүхий байгууллагуудад мэдээллээ хүргүүлэн хүлээгдэж буй төлөвтай байна. | |
| 3 | Арга хэмжээ №3.1.3 Гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан, бусад мэдээг тухай бүр гаргаж удирдлагад танилцуулж байх | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна. | 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хугацаандаа тайлагнаж, үнэлгээний хорооноос А үнэлгээ авсан | Хагас жилээр төлөвлөсөн арга хэмжээ 100 хувь биелэсэн байна | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, сар болон улирлын холбогдох ажлын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээ жилийн эцсийн байдлаар 100% биелэгдээд байна. | 2024.01.02<br>2024.12.15 |
| 4 | Арга хэмжээ №3.1.4 Архивын материалыг цаг тухайд хүлээлгэж өгөх | Цаг тухай бүр хүлээлгэн өгсөн байна. | 2022 оны ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд архивт шилжүүлсэн байна. | Баримт бичиг боловсруулах журам, баримт бичгийн хяналтын журам, архивын үйл ажиллагааны журам, архив бичиг хэргийн стандарт хэрэгжсэн байна. | 2023 оны жилийн эцсийн хяналт шалгалт, улсын байцаагчийн акт, зөрчлийн хэрэг, бусад бичиг баримт материалыг 8 ш архивын нэгж болгон архивт хүлээлгэн өгч ажиллаа. | 2024.01.02<br>2024.12.15 |
| 5 | Арга хэмжээ №3.1.5 Ашиг сонирхлын зөрчлөөс өөрийгөө урьдчилан сэргийлж ажиллах | Ашиг сонирхлын зөрчил гаргаагүй ажилласан байна. | Авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын | 2023 оны ХАСХОМэдүүлгээ хуулийн хугацаанд гарган ажилласан байна. | Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасны дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилансан мэдүүлгийг 2024.02.15-ны өдрийн дотор бүрэн мэдүүлэн ашиг сонирхол гаргаагүй ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.12.15 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | | |
| 6 | Арга хэмжээ №3.1.6 Нийгмийн даатгалын байгууллагын байцаагчийн үйлчлүүлэгчтэй харилцах журамыг мөрдлөгө болгон ажиллах | Журмыг хэрэгжүүлэн мөрдлөг болгон ажилласан байна. | Ёс зүйн зөрчил гаргаагүй ажилласан байна. | Журмыг хэрэгжүүлэн мөрдлөг болгон ажилласан байна. Ёс зүйн зөрчил гаргаагүй ажилласан байна. | Нийгмийн даатгалын байцаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллаж, даатгуулагчаас гомдол санал гаргуулалгүй ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.12.15 |
| 7 | Арга хэмжээ №3.1.7 Удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх | Удирлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг биелүүлсэн байна. | 2023 онд удирдлагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврыг тухай бүр чанартай гаргаж ажилласан байна. | Удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг биелүүлсэн байна. | Эрдэнэбулган сумын Засаг даргын захирамжаар Нийгмийн даатгалын газрын хуваарьт их цэвэрлэгээ хийх газрыг өвсний фондноос замын 2 талын 300 метр газар, Донойн гүүрний хэсэг мод хүртэл өлөнгийн хамт 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр болон 2024 оны 09 дүгээр сарын 23 ны өдрийн Эрдэнэбулган сумын Засаг даргын А/165 захирамжаар “Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах” тухай ажлыг 2 удаа зохион байгуулж тус газар 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр болон 2024 оны 09 дүгээр сарын 28-нд хуваарьт газраа газрын хамт олноороо хог хаягдал цэвэрлэх шуудай, тармуур, хүрзийг бэлтгэн цэвэрлэх талбайн хог хаягдлыг бүрэн цэвэрлэж орчны бохирдлыг цэвэрлэлээ.<br>Цэвэрлэсэн талбайгаас 27 шуудай хог хаягдал гарч, хаягдлыг Эрдэнэбулган сумын ажил хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч, хариуцсан ажлаа үр дүнтэй зохион байгуулсан.<br>2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/272 дугаар аймгийн Засаг даргын захирамжийн дагуу “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих аяныг урд тамирын голын хөвөөнд 4 га талбайд хийсэн юм. Энэ ажлын хүрээнд тус газрын хамт олон 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдөр 38 ширхэг улиас мод тарьж, суулгасан бөгөөд тарьж суулгасан модоо 2024 оны 05 дугаар сарын 10,17, 24, 31-ны өдрүүдэд 4 удаа | 2024.01.02<br>2024.12.15 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | усалж арчлан ажиллалаа. Мөн 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Тариаланчдын цэцэрлэгт хүрээлэн буюу тус газрын хойно 18 ширхэг мод тарьсан.<br>Газрын даргын тушаалаар Архивын өрөөний эвдэрсэн 3 шүүгээг хэвийн ажиллагаатай болгон, архивын баримтуудыг ялган эмхэлж, хадгалах хугацаа дууссан баримтуудыг устгалд оруулан ажилласан байна. | |
| “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг ... хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хө... замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | |
| 1 | Арга хэмжээ № 4.1.1 Нийгмийн даатгалын мэдээллийн шинэчилсэн цогц ( Core) системийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх ажлын зохион байгуулалтанд оролцох, хэрэгжүүлэх | Хэрэглээнд нэвтрүүлсэн мэдээллийн системыг бүрэн ашиглах | 2023 онд core системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан 170 алдаатай мэдээллийг залруулан ажилласан. | Хэрэглээнд нэвтрүүлсэн мэдээллийн системыг бүрэн ашиглах | Мэдээллийн шинэчилсэн цогц систем нэвтрүүлэх бүртгэх өндөр насны, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны, тэтгэврийн тусгай зохицуулалт гээд нийт 496 тэтгэвэр, нас барсан даатгуулагчийн гэр бүлд олгох тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж хянан баталгаажуулахад гарсан алдаа дутагдлыг үйлчилгээний газрын дарга, дээд газарт мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллаа.<br>Шинэ системийг өдөр бүр судалж суралцаж байна. | 2024.01.02<br>2024.12.15 |
| 2 | Арга хэмжээ № 4.1.2 ISO 9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог удирдлага болгон ажиллах | ISO 9001:2015 стандартын дүрэм журмыг хэрэгүүлэх | ISO 9001:2015 стандартын дүрэм журмыг хэрэгүүлэх | ISO 9001:2015 стандартын дүрэм журмыг хэрэгүүлсэн байна | “Баримт бичиг боловсруулах журам, Бүртгэлийн маягтын жагсаалтын журам, Албан хэрэг хөтлөлтийн журам, Сэтгэл ханамжийн судалгааны журам, Өргөдөл, гомдол, санал мэдээллийг хүлээн авах, хянан шийдвэрлэх журам, Үйлчлүүлэгчтэй харилцах журам, Ажлын байрны стандартын журам, Удирдлагын дүн шинжилгээний журам, Үл тохирлын хяналтын журам, Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, Залруулах үйл ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам”болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хүлээн авах журмыг мөрдлөг болгон сахиж ажиллаа.<br>Газрын даргын тушаалаар Архивын өрөөний эвдэрсэн 3 шүүгээг хэвийн ажиллагаатай болгон, архивын баримтуудыг ялган эмхэлж, хадгалах хугацаа дууссан архивын нэгж баримтуудыг устгалд оруулан ажилласан байна. | 2024.01.02<br>2024.12.15 |

Тав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Арга хэмжээ № 5.1 Дээд шатны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах | Зохион байгуулсан сургалтын тоогоор | | Сургалтанд хамрагдсан тоо | НДЕГ-с 2024.01.01-с хэрэгжих Нийгмийн даатгалын багц хуулийн сургалтад 2024.01.09, Аймгийн Онцгой байдлын газрын Гамшигийн үеийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ Газар хөдлөлтийн тухай сургалтад 2024.03.27, НДЕГ-с зохион байгуулсан Коре системийн сургалт 2024.03.29, Аймгийн ЗДТГ-с зохион байгуулсан “Цахим шилжилт” сургалт, ЗДТГ-н “Авилга, ашиг сонирхолын тухай” хуулийн сургалт 2024.04.10, Call pro үйлчилгээний цахим сургалт, Анхны тусламжийн сургалтад 2024.05.31-нд тус бүр хамрагдсан байна. Архангай Прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх” эрхий бүхий албан тушаалтуудад хийсэн Зөрчил шалган шийдвэрлэх нэгдсэн систем шинээр нэвтэрч байгуутай холбогдсон сургалтанд 2024.10.28-ны өдөр мөн 2024.11.08-ны өдөр 2 удаагийн сургалтанд хамрагдан арга зүйн зөвлөгөөг авсан. Зөрчил шалган шийдвэрлэхтэй холбогдуулан НДЕГ-аас 3 удаагийн zoom- сургалтыг зохион байгуулахад тус сургалтуудад бүрэн хамрагдсан. Мөн Архангай аймгийн Төрийн захиргааны албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд 2024.05.14, Захиргааны хэргийн дагнасан шүүхийн тогтолцоо сэдэвт сургалтанд 2024.05.10, Аймгийн Онцгой байдлын газрын Гамшигийн үеийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ Газар хөдлөлтийн тухай сургалтад 2024.03.27, НДЕГ-с зохион байгуулсан Коре системийн сургалт 2024.03.29, Аймгийн ЗДТГ-с зохион байгуулсан “Цахим шилжилт” сургалт, ЗДТГ-н “Авилга, ашиг сонирхолын тухай” хуулийн сургалт 2024.04.10, Нэгдсэн эмнэлгээс зохион байгуулсан яаралтай түргэн тусламжийн үед авах арга хэмжээ | 2024.01.02<br>2024.12.15 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтанд 2024.05.31-ны өдөр хамрагдсан бол Call pro үйлчилгээний цахим сургалт 2024.06.03-ны өдөр тус тус хамрагдсан байна. | | |
| 2 | Арга хэмжээ № 5.2 Хувь хүний ур чадвараа сайжруулах зорилгоор секц дугуйланд хамрагдах | Хамрагдсан секц, дугуйлангийн төрлийн дагуу тэмцээн уралдаанд оролцсон байх | | Анхан шатны тэмцээн уралдаанд оролцсон байх | 2024 онд Монгол бичгийн дунд Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2033 оны “Чингис хааны илгээсэн монгол төрийн бичиг хэрэглэсний 800 жилийн ойг тэмдэглэх тухай” 105 дугаар зарлиг, 2017 оны эх хэлний өдөр зарлах тухай” 25 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”, “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 7 дугаар тогтоол, улмаар 2025 оноос төрийн албан хэргийг крилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжихэд бэлтгэх ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилд 4-р сургуулийн Монгол хэл, уран зохиолын байгшаар байгууллага дээрээ монгол бичиг заалгах ажлыг зохион байгуулж уг сургалтанд 3 удаа хамрагдсан байна.Улсын байцаагчийн шалгалтанд бэлтгэх сургалтуудад бүрэн хамрагдсан.<br><br>Мөн НДЕГ-аас зохион байгуулж буй Монгол бичгийн цахим сургалтанд 6 удаа хамрагдахаас 6 удаа хамрагдаад байна. Санхүүчдын баярыг тохиолдуулан зохион байгуулсан спортын арга хэмжээнд идэвхитэй оролцон. | 2024.01.02<br>2024.12.15 | |

ТАЙЛАН БИЧСЭН:

Хяналтын байцаагч .......................................... / Т.Эрдэнэпил / 2024.12.06
/Албан тушаал / /нэр, гарын үсэг / / огноо /

ҮНЭЛЖ БАТАЛГААЖУУЛСАН:

Хяналт, шалгалт, дотоод аудитын тасгийн дарга .......................................... / Д.Гэрэлчимэг / 2024.12.06
/Албан тушаал / /нэр, гарын үсэг / / огноо /